


Үндэсний хөгжлийн газрын даргын 2018
оны 06 дугаар сарын 06 өдрийн
А-92 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



**Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангахуйц
санхүүгийн тогтвортой байдлын үр ашигтай механизмыг
бүрдүүлэх загварыг боловсруулах суурь судалгаа
хийх зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар**

Зөвлөх үйлчилгээний нэр: Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангахуйц санхүүгийн тогтвортой байдлын үр ашигтай механизмын загварыг боловсруулах суурь судалгаа
Гэрээний төрөл: Хуулийн этгээд
Хэрэгжүүлэгч байгууллага: Үндэсний хөгжлийн газар
Гэрээний хугацаа: 5 сар (Гэрээнд талууд гарын үсэг зурснаар эхэлнэ)

1.ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс 1990 онд зах зээлийн шилжилтийг эхлүүлснээс хойшхи 27 жилийн хугацаанд улс орны эдийн засгийн өсөлт тогтворгүй, зөвхөн уул уурхай, мал аж ахуй дээр тулгуурласан, гадаад зах зээлээс ихээхэн хамааралтай, экспортын барааны тоо, хэмжээ нэр төрөл цөөрч, гадаад, дотоод өрийн хэмжээ нэмэгдэж, санхүүгийн тогтвортой байдал алдагдаж, бодит эдийн засаг болоод ажилгүйдэл, ядуурал зэрэг асуудал анхаарал татсан хэвээр байна.

Учир нь Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоог халсны үр дүнд эдийн засгийн бодит салбаруудын хооронд тогтсон аж ахуйн (санхүү, ажиллах хүч, түүхий эд, техник технологи, хангамж, борлуулалтын) холбоос тасарны улмаас салбаруудын хөгжлийн бодлогын уялдаа байхгүй болж, эдийн засгийн хөгжлийн дунд болон урт хугацааны бодлого төлөвлөлтийн тогтолцоо устаж үгүй болсонтой холбоотой юм.

Өнгөрсөн хугацаанд урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хийх хэд хэдэн оролдлого байсан боловч тэдгээрийн хэрэгжилт сул, бодит бус, улс орны санхүүгийн нөөц, чадамжтай уялдаагүй, санхүүгийн институциудын үйл ажиллагаа, үйлчилгээний нэр төрөл цөөхөн, чанар сул байсны улмаас төдийлөн үр дүнд хүрээгүй байна. Мөн түүнчлэн, улс орны санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиг үүрэг бүхий мөнгө, зээл, санхүү, төсөв, даатгалын асуудал хариуцсан байгууллагуудын эдийн засгийн салбарууд болон салбар хоорондын болон урт, дунд хугацааны хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүрэг тодорхойгүй байна. Мөн дөрвөн жил тутам болдог сонгуулийн мөчлөг, хэрэгждэггүй бодлогын баримт бичгүүд хэт олширсон зэргээс үүдэн урт болон дунд хугацааны хөгжлийн зорилтуудыг үр дүнтэй хангахуйц санхүүгийн тогтвортой байдлыг хангах тогтолцоо үгүйлэгдэж байна.

Сүүлийн жилүүдэд банк, санхүүгийн зуучлагч байгууллагуудын активын хэмжээ нэмэгдэж, санхүүгийн бүтээгдэхүүний нэр төрөл олширсон ч гэсэн нийгэм, эдийн засгийн өнөөгийн хөгжил нь банк хоорондын зах зээл давамгалсан энэхүү салбараас ихээхэн хамааралтай байгаа нь бизнес эрхлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн урт

хугацаатай, бага хүүтэй, хөрвөх чадвар бүхий хямд санхүүгийн эх үүсвэр, хэрэгслүүдээр дутагдсан, төрийн санхүүгийн бодлого, мөнгөний бодлогууд нь үрэлгэн, эдийн засгийн хөгжлийг тэтгэж чадахгүй, аж ахуйн нэгжүүд хуримтлалыг үүсгэж чадахгүй байгааг илтгэж байна. Түхйлбал, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, зарлага, санхүүжилтийг хэмнэлттэй зарцуулах, санхүүгийн хяналтыг хүчтэй болгож, төсвийн алдагдлыг багасгах, төрийн худалдаа аялалтаар бодлогоор дамжуулан үндэсний аж ахуй эрхлэгчдийг дэмжих, санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагаа, тэдгээрийн хоорондын уялдааг хангах зэрэг асуудлуудыг цогцоор нь авч хэрэгжүүлэх шаардлага үүсээд байна.

Үндэсний хөгжлийн газар нь өөрийн чиг үүргийн хүрээнд Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэх болон "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" /МУТХҮБ-2030/-ыг хэрэгжүүлэх хүрээнд эдийн засгийн урт хугацааны хөгжлийг хангахуйц санхүүгийн салбарын тэнцвэртэй байдлыг хангах үр ашигтай механизмыг бүрдүүлэх загварыг боловсруулах судалгааны ажлыг гүйцэтгэх шаардлагатай байна.

2. АЖЛЫН ЗОРИЛГО

"МУТХҮБ-2030"-ын дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхэд эдийн засгийн тэргүүлэх салбарыг хөгжүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад шаардлагатай санхүүгийн тогтвортой байдлын тогтолцоог бий болгох, санхүүгийн зах зээлийн оновчтой бүтэц, зохион байгуулалт, институциудын чиг үүрэг, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, хяналт, зохицуулалтын үр ашигтай механизмыг бүрдүүлэх загварыг боловсруулахад оршино.

3. ХИЙХ АЖЛЫН ХҮРЭЭ

Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын өгөх ерөнхий чиглэлийн дагуу судалгааг хийнэ. Энэ хүрээнд дараах судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

1. 1990 оноос хойш санхүүгийн салбарт хэрэгжсэн болон хэрэгжиж буй хууль, эрх зүйн акт, бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнүүдийн эдийн засгийн салбаруудын хөгжилд хэрхэн нөлөө үзүүлсэн талаар үнэлгээ өгөх;
2. 1990 оноос хойш санхүүгийн тогтвортой байдлыг хангахад оролцогч субъектуудын (Монгол банк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо) бүтэц зохион байгуулалт, чиг үүргийн хэрэгжилт, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоонд шинжилгээ хийх;
3. Хөрөнгийн бирж, банк хоорондын зах зээл, төрийн санхүүгийн бодлогын хэрэгжилтийн төлөв байдлыг шинжлэх, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоог судлах, эдийн засгийн тогтвортой хөгжлийг тэтгэх үр ашигтай механизмыг боловсруулах санал гаргах;
4. "МУТХҮБ-2030"-ийн тогтвортой эдийн засгийн зорилтуудыг хэрэгжүүлэх тэргүүлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн бодлого, зохицуулалтын үр ашигтай механизмыг тодорхойлон зөвлөмж гаргах. Үүнд дараах асуудлуудыг шинжлэх:
 - 4.1. Нэгдсэн төсвийн төлөвлөлтийн өнөөгийн байдалд шинжилгээ хийх;
 - 4.2. Татварын бодлого, тогтолцоонд шинжилгээ хийх, эдийн засагт үзүүлж байгаа нөлөөг тодорхойлох, улсын болон орон нутгийн төсөвт татваруудын хуваарилалтад үнэлгээ, дүгнэлт гаргах;

4.3. Эдийн засгийн салбаруудын урт дунд хугацааны хөгжлийг хангахад Засгийн газрын худалдан авалт болон төсвийн урсгал, зардал, татаас, шилжүүлэг, хөрөнгө оруулалтын бодлогын үр ашигт үнэлгээ өгөх;

4.4. Санхүүгийн тогтвортой байдалд бичил санхүүгийн зах зээл, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл болон аж ахуйн нэгжийн санхүүгийн үзүүлж буй нөлөөнд үнэлгээ хийх;

4.5. Дунд хугацаанд боловсруулах (хөнгөн, хүнсний үйлдвэрлэл) салбарын хөгжлийг дэмжсэн ажлын байрыг нэмэгдүүлэх, инфляцийн түвшинг бууруулах зорилтыг хангасан санхүүгийн бодлогын (төсөв, мөнгө, зээл, хүү, хадгаламж, валютын ханш, хяналтын бодлого) механизмыг тодорхойлон зөвлөмж гаргах.

5. Эдийн засгийн урт болон дунд хугацааны хөгжлийг тэтгэсэн санхүүгийн тогтвортой байдлыг хангаж байгаа олон улсын туршлагыг судалж манай орон нэвтрүүлэх арга, аргачлал, арга зүйг тодорхойлох;

6. Эдийн засгийн урт болон дунд хугацааны хөгжлийг хангах санхүүгийн тогтвортой байдлыг хангахуйц санхүүгийн системийн институцийн оновчтой тогтолцоо, үр ашигтай механизмыг бүрдүүлэх загварыг тодорхойлох.

4. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

“МУТХҮБ-2030”-ийн зорилтуудыг хэрэгжүүлэх тэргүүлэх салбар, арга хэмжээг тэтгэсэн санхүүгийн тогтвортой механизмыг шинжлэн тодорхойлсон судалгааны баримт материалууд байх юм. Судалгааны баримт материалуудыг дараах хэлбэр, хуваарийн дагуу Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүлээлгэн өгөх болно.

	Хүрэх үр дүн	Хугацаа
1	Судалгааны ажлын төлөвлөгөө, аргачлал гарсан байна.	Гэрээ байгуулснаас хойш 5 хоногийн дотор
2	2.1. Санхүүгийн салбарт хэрэгжсэн болон хэрэгжиж буй хууль эрх зүйн акт болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах субъектуудын үйл ажиллагааны уялдаа холбоонд шинжилгээ хийсэн тайлан; 2.2. Хөрөнгийн бирж, банк хоорондын зах зээл, төрийн санхүүгийн бодлогын хэрэгжилтийн төлөв байдлын шинжлэгээ хийж, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоонд хийсэн дүн шинжилгээний тайлан гарсан байна.	Гэрээ байгуулснаас хойш 40 хоногт
3	Нэгдсэн төсвийн төлөвлөлт, татварын бодлого, тогтолцоонд шинжилгээ хийсэн, Засгийн газрын худалдан авалт болон төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын үр ашигт үнэлгээ, зөвлөмж өгсөн тайлан гарсан байна.	Гэрээ байгуулснаас хойш 70 хоногт
4	Санхүүгийн тогтвортой байдалд мөнгөний бодлогын хэрэгжилт, бичил санхүүгийн зах зээл, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл, аж ахуйн нэгжийн санхүүгийн үзүүлж буй нөлөөнд үнэлгээ, зөвлөмж өгсөн тайлан гарсан байна.	Гэрээ байгуулснаас хойш 110 хоногт
5	5.1. МУТХҮБ-2030-ийн зорилтуудыг хангахуйц санхүүгийн тогтвортой байдлын олон улсын туршлагыг судлах, манай орон тэдгээрийг нэвтрүүлэх арга, аргачлал, арга зүйг	Гэрээ байгуулснаас

<p>тодорхойлсон зөвлөмж; 5.2. Дунд хугацаанд хөгжлийн бодлогыг дэмжсэн санхүүгийн системийн институцийн (Монгол банк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж гэх мэт) үйл ажиллагааны уялдааг хангахуйц санхүүгийн үр ашигтай механизмын загварыг боловсруулсан тайлан гарсан байна.</p>	<p>хойш 150 хоногт</p>
----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------

Дээрх гол үр дүнг боловсруулах явцын тайланг дараах хугацаанд ирүүлнэ.

	Үр дүнгийн явцын тайлан	Хугацаа
1	Эхлэлийн тайлан	Гэрээ байгуулснаас хойш 10 хоногийн дотор
2	1 дэх явцын тайлан	Гэрээ байгуулснаас хойш 50 хоногт
3	2 дэх явцын тайлан	Гэрээ байгуулснаас хойш 80 хоногт
4	5 үр дүнг боловсруулсан ажлын явцын эцсийн тайлан	Гэрээ байгуулснаас хойш 150 хоногт

5. АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Уг зөвлөх үйлчилгээг нь хамгийн багадаа 6 зөвлөх бүхий хуулийн этгээд 5 сарын хугацаанд гүйцэтгэнэ.

6. МЭРГЭШСЭН БАЙДАЛ, УР ЧАДВАРТ ТАВИХ ШААРДЛАГА

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Санхүү, эдийн засгийн чиглэлээр мэргэжлийн судалгаа эсвэл зөвлөх үйлчилгээ гүйцэтгэж байсан 3-аас доошгүй жилийн туршлагатай;
- Төсөв, банк, бичил санхүү, хөрөнгийн биржтэй холбоотой хууль эрх зүйн актуудад судалгаа шинжилгээ хийж байсан, эсвэл зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байх.

Зөвлөхүүд нь дараах ур чадвартай байна. Үүнд.

1. Багийн ахлагч / Макро түвшний санхүүгийн бодлогын зөвлөх

- Санхүү, статистик, эдийн засаг, хөгжлийн бодлого эсвэл төрийн захиргааны чиглэлээр доктор болон түүнээс дээш зэрэгтэй;
- Төсөв, татвар, мөнгөний бодлого төлөвлөлт эсвэл төсвийн удирдлага, санхүүжилтын чиглэлээр төрийн захиргаа болон эрдэм шинжилгээний байгууллагуудад 8 болон түүнээс дээш ажилласан туршлагатай;
- Санхүүгийн салбарын хууль эрх зүй, бодлого, журамд дүн шинжилгээ хийж байсан болон эдийн засгийн салбаруудын урт болон дунд хугацааны бодлого, төлөвлөгөө боловсруулж байсан, судалгаа шинжилгээ хийж байсан туршлагатай;
- Статистик шинжилгээний Stata, R, Matlab, эсвэл EViews гэх мэт ижил төстэй програм хангамж ашиглаж байсан туршлагатай;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудын талаар ойлголттой;
- Тайлан, зөвлөмж боловсруулж байсан туршлагатай байх;
- Системийн шинжилгээ хийх ур чадвар, туршлагатай, бодлого төлөвлөлтийн арга техникийг эзэмшсэн;

(vi) Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх.

2. Мөнгөний бодлогын зөвлөх

- (i) Санхүү, статистик, эдийн засаг, хөгжлийн бодлого эсвэл төрийн удирдлагын чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй;
- (iii) Мөнгө, санхүүгийн чиглэлээр дүн шинжилгээ, судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийж байсан туршлагатай;
- (iv) Санхүүгийн чиглэлийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын туршлагатай байх;
- (v) Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудын талаар ойлголттой;
- (vi) Статистик шинжилгээний Stata, R, Matlab, эсвэл EViews гэх мэт ижил төстэй програм хангамж ашиглаж байсан туршлагатай;
- (vii) Тайлан боловсруулж байсан туршлагатай;
- (viii) Системийн шинжилгээ хийх ур чадвар, туршлагатай, бодлого төлөвлөлтийн арга техникийг эзэмшсэн;
- (ix) Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх.

3. Банкны салбарын бодлогын зөвлөх

- (i) Банк санхүү, статистик, эдийн засаг, эдийн засгийн математик загварчлал чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй;
- (ii) Банк, санхүүгийн чиглэлээр дүн шинжилгээ, судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийж байсан туршлагатай;
- (iii) Санхүүгийн чиглэлийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын туршлагатай байх;
- (iv) Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудын талаар ойлголттой;
- (v) Статистик шинжилгээний Stata, R, Matlab, эсвэл EViews гэх мэт ижил төстэй програм хангамж ашиглаж байсан туршлагатай;
- (vi) Тайлан, зөвлөмж боловсруулж байсан туршлагатай Системийн шинжилгээ хийх ур чадвар, туршлагатай, бодлого төлөвлөлтийн арга техникийг эзэмшсэн;
- (vii) Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх.

4. Даатгалын салбарын бодлогын зөвлөх

- (i) Банк, санхүү, статистик, эдийн засаг, даатгал, эдийн засгийн математик загварчлалын чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй;
- (ii) Даатгал, санхүүгийн чиглэлээр дүн шинжилгээ, судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийж байсан туршлагатай;
- (iii) Санхүүгийн чиглэлийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээний хийх ажлын туршлагатай байх;
- (iv) Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудын талаар ойлголттой;
- (v) Статистик шинжилгээний Stata, R, Matlab, эсвэл EViews гэх мэт ижил төстэй програм хангамж ашиглаж байсан туршлагатай;
- (vi) Тайлан, зөвлөмж боловсруулж байсан туршлагатай Системийн шинжилгээ хийх ур чадвар, туршлагатай, бодлого төлөвлөлтийн арга техникийг эзэмшсэн;

(vii) Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх.

5. Хөрөнгийн зах зээлийн салбарын бодлогын зөвлөх

- (i) Санхүү, статистик, эдийн засаг, эдийн засгийн математик загварчлалын чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй;
- (ii) Хөрөнгийн бирж болон биржийн бус зах зээлийн чиглэлээр дүн шинжилгээ, судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийжбайсан туршлагатай;
- (iii) Санхүүгийн чиглэлийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээний хийх ажлын туршлагатай байх;
- (iv) Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудын талаар ойлголттой;
- (v) Статистик шинжилгээний Stata, R, Matlab, эсвэл EViews гэх мэт ижил төстэй програм хангамж ашиглаж байсан туршлагатай;
- (vi) Тайпан, зөвлөмж боловсруулж байсан туршлагатай Системийн шинжилгээ хийх ур чадвар, туршлагатай, бодлого төлөвлөлтийн арга техникийг эзэмшсэн;
- (vii) Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх.

6. Банк бус санхүү, бичил санхүүгийн зах зээлийн салбарын бодлогын зөвлөх

- (i) Санхүү, статистик, эсвэл эдийн засгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй;
- (ii) Банк бус санхүү, бичил санхүүгийн зах зээлийн чиглэлээр дүн шинжилгээ, судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийжбайсан туршлагатай;
- (iii) Санхүүгийн чиглэлийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээний хийх ажлын туршлагатай байх;
- (iv) Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудын талаар ойлголттой;
- (v) Статистик шинжилгээний Stata, R, Matlab, эсвэл EViews гэх мэт ижил төстэй програм хангамж ашиглаж байсан туршлагатай;
- (vi) Тайлан, зөвлөмж боловсруулж байсан туршлагатай Системийн шинжилгээ хийх ур чадвар, туршлагатай, бодлого төлөвлөлтийн арга техникийг эзэмшсэн;
- (vii) Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх.

7. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БОЛОН ТАЙЛАГНАХ МЕХАНИЗМ

Зөвлөх баг нь ҮХГ-тай гэрээ байгуулах бөгөөд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргад шууд тайлагнана. ҮХГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь зөвлөх үйлчилгээ явуулахад шаардлагатай удирдамж, дэмжлэгээр хангана. Дэмжлэг дараах зүйлсийг багтаах бөгөөд зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй:

- Төрийн болон бусад оролцогч талуудтай холбоо тогтоож өгөх,
- Холбогдох мэдээллийг олж өгөхөд дэмжлэг үзүүлэх
- Оролцогч талуудын уулзалт, зөвлөгөөн хийхэд дэмжлэг үзүүлэх,
- Ерөнхий удирдамж өгөх болон шаардлагатай захиргааны бусад дэмжлэг.
- ҮХГ нь энэхүү даалгаврын үр дүнд зохиогчийн эрх эзэмшинэ.

8. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Уг үр дүнг хүлээлгэж өгсөн болон ХБТХ-ийн даргын ахалсан ажлын хэсэг гэрээнд заасан үр дүнг хүлээн авсныг баталгаажуулсны үндсэн дээр олгоно.

Огноо	Төлбөрийн хэсэг	Төлбөрийн нөхцөл
Үр дүн 1:	40%	ҮХГ-ын саналыг тусгаж хүлээж авсны үндсэн дээр
Үр дүн 2:		
Үр дүн 3:		
Үр дүн 4:	30%	
Үр дүн 5:	30%	